

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ОРА-2026/002/НА-СТА-ЗГТС**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг  
2026 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва  
Утас: 70353088 Цахим хаяг: [purevkhagvap@audit.gov.mn](mailto:purevkhagvap@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: [buyanundrakhb@audit.gov.mn](mailto:buyanundrakhb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Т.Болормаа  
Утас: 70350757 Цахим хаяг: [bolormaat@audit.gov.mn](mailto:bolormaat@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,  
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033

Утас: (976) 7035 9826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.25 № 94  
танай -ны № -т

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.НАРМАНДАХ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны орлогыг 217,806.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 191,122.2 сая төгрөгийн орлого төвлөрч 87.7%-ийн биелэлттэй тайлагнасан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого тайланд онд 26,684.7 сая төгрөгөөр тасарсан нь Нийгмийн даатгалын ерөнхий газраас орлогын төлөвлөгөөг бодитой, үндэслэлтэй баталдаггүйтэй холбоотой байна.

#### Аудитын гол асуудал

Орхон аймгийн Нийгмийн даатгалын сан тайлант оны 10 дугаар сараас эхлэн төсөв хүрэлцээгүйгээс шалтгаалж ажилгүйдлийн тэтгэмж 2,793.3 сая төгрөг, ҮОМШӨ-ний тэтгэмж 40.7 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн өглөг 1,853.8 сая төгрөг нийт 4,687.7 сая төгрөгийн тэтгэмжийг олгоогүй өр төлбөрөөр бүртгэсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсоноос хойш 4 дэх жилдээ гүйцэтгэж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас даргыг томилох асуудлыг одоог хүртэл шийдвэрлээгүй байсаар байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ПҮРЭВЛХАГВА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,513,349,502.15	23,279,738,577.33
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,568,923,107.65	12,425,525,869.04
31200	1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө	15,568,923,107.65	12,425,525,869.04
31210	1.1.1.02.01 Төгрөг	15,568,923,107.65	12,425,525,869.04
31213	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь харилцах	15,568,923,107.65	12,425,525,869.04
33	1.1.3 АВЛАГА	8,944,426,394.50	10,854,212,708.29
33300	1.1.3.03 Татаас, санхүүжилтийн авлага	3,853,721,777.41	3,842,723,317.41
33402	1.1.3.06 Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	5,020,164,932.03	6,774,665,152.04
33500	1.1.3.07 Бусад авлага	70,539,685.06	236,824,238.84
33510	1.1.3.07.01 Байгууллагаас авах авлага	33,827,215.13	145,473,132.93
33520	1.1.3.07.02 Хувь хүмүүсээс авах авлага	36,712,469.93	91,351,105.91
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	24,513,349,502.15	23,279,738,577.33
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,725,737,661.76	7,263,127,304.70
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,725,737,661.76	7,263,127,304.70
41300	2.1.1.03 Өглөг	2,342,556,212.39	5,831,203,091.62
41360	2.1.1.03.06 Бусад өглөг	2,342,556,212.39	5,831,203,091.62
41361	2.1.1.03.06.01 Байгууллагад төлөх өглөг	97,156,373.87	1,061,443,961.80
41362	2.1.1.03.06.02 Хувь хүмүүст төлөх өглөг	2,245,399,838.52	4,769,759,129.82
41400	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	1,383,181,449.37	1,431,924,213.08
41410	2.1.1.04.01 Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	1,383,181,449.37	1,431,924,213.08
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20,787,611,840.39	16,016,611,272.63
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	20,787,611,840.39	16,016,611,272.63
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	20,787,611,840.39	16,016,611,272.63
51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	24,180,904,236.29	20,850,085,335.91
51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	(3,393,292,395.90)	(4,833,474,063.28)
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	24,513,349,502.15	23,279,738,577.33

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	385,494,963,048.70	441,234,241,066.19
11	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	173,238,285,802.92	192,203,271,362.27
112	1.1.1.03.2 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	173,238,285,802.92	192,203,271,362.27
1122	1.1.1.03.2.01 Тэтгэврийн даатгалын шимтгэл	140,168,332,270.81	155,822,297,404.94
112001	1.1.1.03.2.01.03 Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	140,168,332,270.81	155,822,297,404.94
112002	1.1.1.03.2.02 Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	14,886,175,070.27	16,559,814,283.94
112003	1.1.1.03.2.03 ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	12,679,471,226.26	13,747,176,831.96
112004	1.1.1.03.2.04 Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	5,504,307,235.58	6,073,982,841.43
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	124,646,339.22	249,030,969,703.92

120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	124,646,339.22	652,233,682.92
1201	1.1.1.04.1.02 Хүүгийн орлого	103,048,121.61	128,061,840.96
120002	1.1.1.04.1.02.02 Бусад хүүгийн орлого	103,048,121.61	128,061,840.96
120003	1.1.1.04.1.03 Торгуулийн орлого	9,799,500.00	13,177,200.00
120009	1.1.1.04.1.09 Бусад орлого	11,798,717.61	510,994,641.96
122	1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	248,378,736,021.00
1221	1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	-	248,378,736,021.00
12215	1.1.1.04.3.01.05 Төсөв хоорондын хандив, тусламж	-	43,817,686,240.00
122152	1.1.1.04.3.01.05.2 НДС-д УТ-с олгох татаасын орлого \УТ-НДС\	-	43,817,686,240.00
122004	1.1.1.04.3.01.07 НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого\	-	204,561,049,781.00
13	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	212,132,030,906.56	-
1310	1.1.1.05.1 Улсын төвлөрсөн төсвөөс	35,081,699,356.56	-
131001	1.1.1.05.1.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	35,081,699,356.56	-
1330	1.1.1.05.4 Төсвийн захирагчдаас	177,050,331,550.00	-
133002	1.1.1.05.4.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	177,050,331,550.00	-
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	388,888,255,444.60	446,067,715,129.47
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	388,888,255,444.60	446,067,715,129.47
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,925,311.00	19,986,145.00
2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,925,311.00	19,986,145.00
210801	1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,688,001.00	8,581,315.00
210808	1.1.2.01.1.08.08 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,237,310.00	11,404,830.00
213	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	388,872,330,133.60	446,047,728,984.47
2131	1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	191,128,699,067.43
21311	1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	191,128,699,067.43
213104	1.1.2.01.4.01.01.5 НДС-н орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	191,128,699,067.43
2132	1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	216,955,771,558.25	254,919,029,917.04
213202	1.1.2.01.4.02.01 Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	216,955,771,558.25	254,919,029,917.04
2135	1.1.2.01.4.05 Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	171,916,558,575.35	-
213503	1.1.2.01.4.05.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	171,916,558,575.35	-
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(3,393,292,395.90)	(4,833,474,063.28)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(3,393,292,395.90)	(4,833,474,063.28)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	417,346,590,646.13	476,194,864,856.28
11	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	205,451,006,811.93	190,639,685,413.48
112	1.1.1.1.03.2 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	205,451,006,811.93	190,639,685,413.48
1122	1.1.1.1.03.2.01 Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	138,198,242,646.54	154,615,402,484.87

112001	1.1.1.1.03.2.01.03 Бусад тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого	138,198,242,646.54	154,615,402,484.87
112002	1.1.1.1.03.2.02 Тэтгэмжийн даатгалын шимтгэлийн орлого	14,623,973,399.75	16,405,135,418.56
112003	1.1.1.1.03.2.03 ҮОМШ өвчний даатгалын шимтгэлийн орлого	15,727,098,976.74	13,605,874,660.38
112004	1.1.1.1.03.2.04 Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого	5,651,476,210.08	6,013,272,849.67
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	167,884,684.20	285,555,179,442.80
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	167,884,684.20	37,165,444,961.80
1201	1.1.1.1.04.1.02 Хүүгийн орлого	103,048,121.61	128,106,507.69
120002	1.1.1.1.04.1.02.02 Бусад хүүгийн орлого	103,048,121.61	128,106,507.69
120009	1.1.1.1.04.1.09 Бусад орлого	64,836,562.59	37,037,338,454.11
122	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	248,389,734,481.00
1221	1.1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	-	248,389,734,481.00
12215	1.1.1.1.04.3.01.05 Төсөв хоорондын хандив, тусламж	-	43,828,684,700.00
122152	1.1.1.1.04.3.01.05.2 НДС-д УТ-с олгох татаасын орлого (УТ-НДС)	-	43,828,684,700.00
122004	1.1.1.1.04.3.01.07 НДС-ын санхүүжилтийн шилжүүлгийн орлого\	-	204,561,049,781.00
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	211,727,699,150.00	-
1310	1.1.1.1.05.1 Улсын төвлөрсөн төсвөөс	34,677,367,600.00	-
131001	1.1.1.1.05.1.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	34,677,367,600.00	-
1330	1.1.1.1.05.4 Төсвийн захирагчдаас	177,050,331,550.00	-
133002	1.1.1.1.05.4.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	177,050,331,550.00	-
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	419,057,219,894.91	479,338,262,094.89
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	419,057,219,894.91	479,338,262,094.89
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,842,790.93	100,568,218.51
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,925,311.00	19,986,145.00
210801	1.1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,688,001.00	8,581,315.00
210808	1.1.1.2.01.1.08.08 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,237,310.00	11,404,830.00
2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	28,917,479.93	80,582,073.51
210901	1.1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал	28,917,479.93	80,582,073.51
213	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	419,012,377,103.98	479,237,693,876.38
2131	1.1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	226,840,790,526.27
21311	1.1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	226,840,790,526.27
213104	1.1.1.2.01.4.01.01.5 НДС-ын орлогын төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	226,840,790,526.27
2132	1.1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	214,835,346,896.43	252,396,903,350.11
213202	1.1.1.2.01.4.02.01 Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	214,835,346,896.43	252,396,903,350.11
2135	1.1.1.2.01.4.05 Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	204,177,030,207.55	-
213503	1.1.1.2.01.4.05.02 Төвлөрүүлэх шилжүүлэг	204,177,030,207.55	-
III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(1,710,629,248.78)	(3,143,397,238.61)

VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(1,710,629,248.78)	(3,143,397,238.61)
101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,279,552,356.43	15,568,923,107.65
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,568,923,107.65	12,425,525,869.04

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1.1.1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,921,255,925.11	24,921,255,925.11
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(740,351,688.82)	(740,351,688.82)
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,180,904,236.29	24,180,904,236.29
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	(3,393,292,395.90)	(3,393,292,395.90)
10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,787,611,840.39	20,787,611,840.39
11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	20,787,611,840.39	20,787,611,840.39
12	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	62,473,495.52	62,473,495.52
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,850,085,335.91	20,850,085,335.91
19	1.7 Тайлант үеийн үр дүн	(4,833,474,063.28)	(4,833,474,063.28)
20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	16,016,611,272.63	16,016,611,272.63

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй болно.

Аудитаар нийт 118.7 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 5.4 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 113.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 3.2 Албан шаардлага

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраас чөлөөлөгдсөн алба хаагчид ажилгүйдлийн тэтгэмж олгохдоо давуу байдал үүсгэн 76 хоногт 4 удаа хувааж олгох тэтгэмжийг 1 өдөрт бөөн дүнгээр 5.4 сая төгрөгийг олгосон зөрчилд 1 зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Тодруулга тайлантай холбоотой асуудал

#### Илрүүлэлт :

Нийгмийн даатгалын сангийн жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад бэлтгэж ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-т "санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025-01-03-ны өдрийн А/3 тушаалаар "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх зааврыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Санхүүгийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж байх.

## **2. Авлагатай холбоотой асуудал**

### **Илрүүлэлт :**

Ажилгүйдлийн даатгалын сангаас 121 иргэнд 113.3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг илүү олгож авлага үүсгэн дотоод хяналт алдагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"; 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

### **Өгсөн зөвлөмж :**

Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмжийг илүү олгоггүй, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын сангийн жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад бэлтгэж ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Ажилгүйдлийн даатгалын сангаас 121 иргэнд 113.3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг илүү олгож авлага үүсгэн дотоод хяналт алдагдсан байна.	1	113.3	-	-	-	-	1	113.3	-	-	-	-
Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраас чөлөөлөгдсөн алба хаагчид ажилгүйдлийн тэтгэмж олгохдоо давуу байдал үүсгэн 76 хоногт 4 удаа хувааж олгох тэтгэмжийг 1 өдөрт бөөн дүнгээр 5.4 сая төгрөгийг олгосон	1	5.4			1	5.4						
Дүн	3	118.7	-	-	1	5.4	2	113.3	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
НИЙТ ДҮН									

### 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	1	1			1			
4	ТТЗ								
5	ОНӨҮГ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			